



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар АМ68

Ховд

Жуух бичгээр шагнах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е" дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 103 жилийн ойн баярыг тохиолдуулан эх орон, ард түмнийхээ төлөө өргөсөн тангарагтаа үнэнч байж, албан үүргээ нэр төртэй гүйцэтгэн, хамт олноо манлайлан, олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 305 дугаар тусгай салбарын ахлах ахлагч Я.Мөнхболд, тогооч А.Сэмжид нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан албан хаагчдад 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Зэвсэгт хүчний 305 дугаар тусгай салбарын захирагч (Т.Мөнхсайхан)-д зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Э.БОЛОРМАА



8400001 03201

Zah A/168-Kh